



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/34

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 тоот тогтоолоор баталсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5, "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг"-ийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэгдэг "Өөдлөн дэвших мандал" ХХК-ий "Арвижих" хүнсний дэлгүүр, Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг "Бүрэн Сэлэнгэ" ХХК-ий хүнсний дэлгүүрүүд нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгаагүй 1 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн зөрчил гаргасан тул "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-үүдийг тус тус 3 сарын хугацаатай түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн аж ахуйн нэгжид мэдэгдэж, зөрчил дутагдлаа арилгаж, үйл ажиллагаагаа сайжруулсан тохиолдолд дахин зөвшөөрөл олгох ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэхийг "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих" ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхжаргал/-д даалгасугай.

3. Тусгай зөвшөөрөл нь түдгэлзсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурдаа А.Энхбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Ж.Огонхүү нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ